

**2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 31-НИЙ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ЗАСАГ ДАРГААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 17.00 цагаас өмнө файл болон цаасан хэлбэрээр баталгаажуулан Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1.	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах арга хэмжээний тухай” А/32 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүх үе шатанд тавих хяналтыг эрчимжүүлж ажиллах.	СТСХ ХААА
2.	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Төсвийн хуваарь батлах тухай” А/47 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, төсвийн орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэх.	СТСХ Татварын хэлтэс
3.	Нийслэлийн хэмжээнд төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр үл хөдлөх хөрөнгийн татварын орлого, бусад орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэх, татварын орлогын бааз суурийг өргөжүүлэх санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах.	СТСХ Татварын хэлтэс
4.	“Хот хөгжлийн индекс” хэрэгжүүлэхтэй холбогдуулан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран ажиллаж, шаардлагатай судалгаа, мэдээ мэдээлэл шуурхай солилцож, ажлаа уялдуулж ажиллах.	ЗДЗ Г.Дагвадорж ЗДТГ
5.	Нийслэлийн хэмжээнд Сар шинийн баярын үзэсгэлэн худалдаа болон Ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхэлж байгаатай холбогдуулан иргэд, хүүхэд, багачуудын амгалан тайван байдлыг хангах, хулгайн болон бусад төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэв журмыг сахиулах ажлуудаа эрчимжүүлэх.	Боловсролын хэлтэс Цагдаагийн хэлтэс
6.	Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай, хүндрэл чирэгдэлгүй үзүүлэх, цаашид урьдчилан сэргийлэх чиглэлээр санал боловсруулж танилцуулах.	НХХ ЭМТ
7.	Золбин нохой, муур устгах ажлыг эрчимжүүлж ажиллах.	ТХҮХ Багахангай тохижилт ОНӨААТҮГ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
8.	ҮАБЗ-өөс ирэх 5 дугаар сард зохион байгуулах газар хөдлөлтийн гамшгийн талаарх дадлага сургуулилтад бэлтгэх	ОБХ

9.	Мэдээллийн цаг арга хэмжээг хэрэгжүүлж, дүүрэгт зохион байгуулагдсан арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 7 хоног тутам иргэд, олон нийтэд мэдээлэх	ЗДТГ Соёлын ордон
10.	Нийслэлийн Засаг даргаас эрх шилжин ирсэн 6 ажлын тендэрийг ойрын хугацаанд зарлах, хөрөнгө оруулалтын ажлуудыг яаралтай зохион байгуулах	ЗДО Б.Болормаа СТСХ ХААА
11.	УИХ-ын гишүүд, НИТХ-ын төлөөлөгч, дүүргийн удирдлагууд 2023 оны 02 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд иргэд болон ААНБ-ын ажилтан, албан хаагчидтай хийх уулзалтын бэлтгэлийг хангаж, хамтран ажиллах	ЗДТГ Хороод ААНБ
12.	2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр “Сар шинийн баяр”-т зориулсан аймаг, цэргийн алдар цолтой хүчит 64 бөхийн барилдаан зохион байгуулагдах тул бэлтгэл ажлыг хангах	НХХ БТСХ
13.	Албан тушаалтнууд, албан хаагчид ХАСХОМ-ээ яаралтай гаргах	ТЗУХ Холбогдох албан тушаалтнууд
14.	Дүүрэгт 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдөр “Цагаан сарын үзэсгэлэн худалдаа” арга хэмжээг зохион байгуулна. Энэхүү арга хэмжээнд бараа бүтээгдэхүүнээ танилцуулах, иргэд ААНБ-тай хамтран ажиллах	ТХҮХ ЖДҮҮДТ
15.	2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр “Багахангай-2023” өвлийн өдөрлөгийн арга хэмжээг зохион байгуулахад албан хаагч, иргэдийн оролцоог хангах	НХХ БТСХ Хороод ААНБ
16.	Сар шинийн баярыг тохиолдуулан ААНБ-ууд харьяалах ахмад настнуудаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх	ААНБ-ууд
17.	Газар зохион байгуулалтын болон газар олголтын талаарх мэдээ мэдээллийг иргэдэд хүргэх үүднээс хороодод хүрч ажиллах	ГЗБА
18.	Дүүргээс 2023 оны зорилтот жилийг “Иргэдийн оролцоо, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан хүрээ бүхий лого хийлгэж, ААНБ-уудад хүргүүлэх	ТЗУХ
19.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил зохион байгуулах	ААНБ-ууд